

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 3

Хуралдаан 2013 нэгдүгээр сарын 31-ний өдрийн 14 цаг 15 минутад эхэлж, 17 цаг 08 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 53 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Сүхбаатар, Өмнөговь, Орхон аймагт зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Сүхбаатар, 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Өмнөговь, 2013 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Орхон аймагт тус тус зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Сүхбаатар аймагт 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, Өмнөговь аймагт 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр, Орхон аймагт 2013 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр аймагт тус тус зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий нийт 318 иргэн, үүнээс 174 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д, нэр бүхий 144 иргэнийг “Туслах түшмэлийн</p>

		<p>ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д тус тус бүртгэснийг 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д тус тус бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 27 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 16 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 7, 8, 9, 10, 11, 12 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 43 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Сүхбаатар, Өмнөговь, Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Хүний эрхийн үндэсний комиссын Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр</p>

		<p>сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Александрын Дашдэлэгийг Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан Александрын Дашдэлэгийг Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, тус Комиссын Ажлын албаны даргад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Зам тээврийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Зам, тээврийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Рэнцэнгийн Оног томилуулахаар дүгнэлт гарган, нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батзаяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон</p>

	тухай	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Сундуйн Энхтуулыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батзаяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Зам тээврийн яамны Зам тээврийн хяналт, бүртгэлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Зам тээврийн яамны Зам тээврийн хяналт, бүртгэлийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай асуудлыг хойшлуулав.</p>
6	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын даргын албан тушаалд Бавуудоржийн Алтансүхийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Мэдээллийн</p>

		<p>технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Жадамбаад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	<p>Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Э.Тэгшбаяраас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Э.Тэгшбаяраас түүнд сахилгын шийтгэл ногдуулан төрийн албанаас халсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” 1027 дугаар тушаалыг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан гомдол хууль ёсны үндэслэлтэй эсэхийг хянан шалгахаар томилогдон ажилласан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 3-ын “б”-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Э.Тэгшбаярыг Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаал эрхэлж байхад нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3-д заасан “төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” сахилгын шийтгэл ногдуулсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” 1027 дугаар тушаал нь хууль зөрчсөн гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p>

		<p>2. Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаал эрхэлж байсан Э.Тэгшбаярт сахилгын шийтгэл ногдуулсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” захиргааны акт болох 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1027 дугаар тушаалыг хүчингүй болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	<p>Бусад асуудал:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албаны зөвлөлийн орон тооны бус гишүүн, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б. Болдбаатарын хүсэлтэд хариу өгөх • Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдийн ажил, үүргийн хуваарь, Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэгд өөрчлөлт оруулах тухай санал 	<p>Стандартчилал, хэмжил зүйн газраас баталсан “Нээлттэй эхийн систем” стандартыг нарийвчлан судлахын зэрэгцээ стандартыг хэзээ, хэрхэн, яаж, ямар түвшинд хэрэгжүүлэх, стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдсон чиглэл, заавар гарсан эсэх талаар УИХ-ын Тамгын газраас лавлаж, тодруулахаар тогтлоо. Энэ хугацаанд Төрийн албаны мэргэшлийн шалгалтын санд буй мэдээллийн технологийн сорилоор сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байх нь зүйтэй гэж үзэв.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдээс ирүүлсэн саналд үндэслэн Төрийн албаны зөвлөлийн хуралдааны дэг, Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдийн ажил үүргийн хуваарийг шинэчлэн боловсруулж, дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтлоо.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

